



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2013 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 1/04

Улаанбаатар хот

Нийслэлийн Тээврийн газрын дүрэм,  
бүтэц, орон тооны хязгаар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг нийслэлийн Тээврийн газрын дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тооны хязгаарыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Дүрэм батлагдсантай холбогдуулан ажилтан, албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолт болон үйл ажиллагааны дотоод журмыг дүрэмд нийцүүлэн өөрчилж, ажилтнуудыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоож ажиллахыг нийслэлийн Тээврийн газар/ Ч.Энхбат /-т даалгасугай.


3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 14 дүгээр захирамжийн хавсралтын Нийтийн тээврийн газарт хамаарах заалт, 119 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

Нийслэлийн Засаг даргын 2013 оны  
01 дугаар сарын 24-ны өдрийн  
1/64 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт



## НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Тээврийн газар нь (цаашид “НТГ” гэх) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын тээврийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх, холбогдох шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Нийслэлийн Тээврийн газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Авто тээврийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Нийслэлийн Тээврийн газар нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ажлаа танилцуулж, зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Засаг даргын удирдлагад үйл ажиллагаа явуулж, тэдгээрийн өмнө ажлаа тайлагнана.

1.4. Нийслэлийн Тээврийн газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, Төрийн сан (банк)-нд харилцах данстай байх бөгөөд өөрийн туг, бэлэгдэлтэй байж болно.

### Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Нийслэлийн Тээврийн газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоон баталж, газрын даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Байгууллагын удирдлага нь дарга, орлогч дарга /2/, хэлтсийн дарга нараас бүрдэх бөгөөд нэгжийн хувьд хэлтэс, тасагтай байна.

2.3. Нийслэлийн Тээврийн газрын дарга нь ажилтан, албан хаагчдыг томилж, чөлөөлөх бөгөөд орлогч дарга, хэлтсийн дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана. Орлогч дарга нарыг томилж, чөлөөлөхдөө Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөнө.

2.4. Нийслэлийн Тээврийн газрын даргын дэргэд байгууллагын чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх зөвлөлийг байгуулж ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга тушаалаар батална.

2.5. Нийслэлийн Тээврийн газар нь өдөр тутмын үйл ажиллагаагаа холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, жил, улирлын ажлын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтын дагуу явуулна.

2.6. Нийслэлийн Тээврийн газрын дарга нь холбогдох хууль тогтоомж, газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу батлагдсан төсөвт багтаан ажилтан, албан хаагчдын цалингийн шатлал, шагнал, урамшууллын хэмжээг тогтоож, хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлнэ.

2.7. Нийслэлийн Тээврийн газрын дарга нь холбогдох хууль, тогтоомжоор олгосон бүрэн эрх болон Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор тушаал гаргаж, дүрэм, журам, бусад шийдвэрийг баталгаажуулан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.8. Нийслэлийн Тээврийн газрын даргын түр эзгүй байх хугацаанд түүний зөвшөөрлөөр албан тушаалын эрх үүргийг нь байгууллагын орлогч дарга хэрэгжүүлнэ.

2.9. Нийслэлийн Тээврийн газар нь эд хөрөнгийн эрхийн байдлаар төсөвт байгууллага байх бөгөөд төсвөөс хуваарилсан хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

2.10. Нийслэлийн Тээврийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн зарим ажлыг хуульд нийцүүлэн гэрээгээр гүйцэтгүүлж болно.

2.11. Нийслэлийн Тээврийн газрын дарга Нийслэлийн Засаг даргатай Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ байгуулж, хуульд заасан бусад эрхийг хэрэгжүүлж, үүрэг хүлээж ажиллана.

2.12. Нийслэлийн Тээврийн газрын нь Нийслэлийн Засаг дарга холбогдох эрх бүхий байгууллагын эрх олгосны дагуу гадаад, дотоодын байгууллагатай харилцах, гэрээ байгуулах, хуулийн хүрээнд хэлцэл хийх.

Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1. Нийтийн тээврийн үйлчилгээ;

3.2. Ачаа тээвэр

3.3. Авто үйлчилгээ

3.1. Нийтийн тээврийн талаар:

3.1.1. Нийтийн тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнах;

3.1.2. Улаанбаатар хотын нийтийн тээврийн салбарын дунд болон хэтийн зорилт, стратегийг боловсруулж, хэрэгжилтийг хангах, хамгийн үр ашигтай сүлжээг бий болгох, эрэлт хэрэгцээг тодорхойлох;

3.1.3. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар санал, төсөл боловсруулах, тулгамдсан асуудлыг судалж холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх;

3.1.4. Улаанбаатар хотод нийтийн тээврийн дэвшилтэт технологийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, тээврийн үйлчилгээг орчин үеийн төвшинд хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, мэргэжил боловсролыг дээшлүүлэх;

3.1.5. Нийслэлийг дайран өнгөрч байгаа төмөр замын сүлжээг ашиглан нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах.

### 3.2. Ачаа тээврийн талаар

3.2.1. Ачаа тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнах;

3.2.2. Ачаа тээврийн салбарын дунд болон хэтийн зорилт, стратегийг боловсруулж, хэрэгжилтийг хангах, хамгийн үр ашигтай сүлжээ бий болгох, эрэлт хэрэгцээг тодорхойлох;

3.2.3. Ачаа тээврийн салбарт аюултай, технологийн болон тусгай ачаа тээврийн зохицуулалтыг төлөвлөж хяналт тавих, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

3.2.4. Нийслэлийг дайран өнгөрч байгаа төмөр замын сүлжээг ашиглан ачаа тээврийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах.

### 3.3. Авто үйлчилгээний талаар

3.3.1. Авто үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сан бий болгож, холбогдох дүрэм, журам, стандартыг боловсруулан, хэрэгжилтийг хангуулах, авто үйлчилгээний байгууллагуудад зэрэглэл тогтоох;

3.3.2. Холбогдох стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих.

Дөрөв. Нийслэлийн Тээврийн газрын үүрэг

### 4.1. Нийтийн тээврийн талаарх үүрэг

4.1.1. Нийтийн тээврийн үйлчилгээний автобус, троллейбус болон таксийн тээврийн хэрэгслийн паркийг жил бүр шинэчлэх талаар санал боловсруулан танилцуулах, шаардлагатай тооцоо, судалгааг тогтмол хийх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түлхүү дэмжиж, нөхөн хангалт хийх замаар үе шаттайгаар сайжруулах;

4.1.2. Нийтийн тээврийн салбарт шинэ техник технологи болон шинэ төрлийн тээврийн хэрэгслүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дотоодын хөрөнгө оруулалт болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үндэслэл, судалгааг боловсруулахад оролцох, төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

4.1.3. Нийтийн тээврийн автобусны бүртгэлийн ухаалаг систем, тээвэрлэлтийн цахим төлбөрийн систем нэвтрүүлэх, нийтийн тээврийн салбарт хийгдэж байгаа болон цаашид хийхээр төлөвлөж байгаа ажил, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

4.1.4. Нийслэлийн нийтийн тээврийн автобус, троллейбус, таксийн тээврийн үйлчилгээний хүртээмж нэмэгдүүлэх, холбогдох тооцоо судалгааг үндэслэн чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, баталгаажуулах, тохижуулах, камержуулах, гэрэлтүүлэг хийх, хаягжуулах, тэмдэгжүүлэх талаар судалгаа тооцоо хийж санал боловсруулж зохих байгууллагаар шийдвэрлүүлэх;

4.1.5. Нийтийн тээврийн эрэлт хэрэгцээг хангуулах зорилгоор үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, хөдлөх бүрэлдэхүүнийг шинэчлэх, сүлжээ төлөвлөлт, хөдөлгөөний зохион байгуулалтыг оновчтой, боловсронгуй болгох, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, техник ашиглалтын шаардлагад илүү нийцтэй, эдийн засгийн хэмнэлттэй шинэ төрлийн тээврийн хэрэгслийг сонгож ажиллах талаар бэлтгэл ажлыг хангах, санал, төсөл боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, үйлчилгээний үнэ тарифыг тогтооход холбогдох судалгаа гаргах, санал өгөх;

4.1.6. Зорчигчдын урсгалын судалгааг явуулах, санал дүгнэлт гаргах, үйлчилгээний тогтвортой байдлыг хангаж, чиглэлийн давхцыг бууруулах хөдөлгөөний график, зохион байгуулалтыг оновчтой болгох төлөвлөлтийг боловсруулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх;

4.1.7. Зохих байгууллагуудтай хамтран нийтийн тээврийн автобус, таксийн зогсоолуудын талбайн хэмжээг тогтоох, буудал, зогсоолын мэдээллийн нэгдсэн санг бий болгох;

4.1.8. Хот доторхи болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээний шугам чиглэл бүрээр орлого, зардлын тооцоог хийх, алдагдалтай ажиллах чиглэлийн алдагдлыг нөхөх асуудлыг боловсруулж Нийслэлийн удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх;

4.1.9. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, судалгаа хийх, нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн чөлөөтэй өрсөлдөх нөхцөл, тэгш боломжийг бүрдүүлэх;

4.1.10. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгоход мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх, ажилтнуудыг туршлага судлах арга хэмжээнд хамруулах;

4.1.11. Нийтийн тээврийн салбарын үйл ажиллагаа болон бодлого, зорилт, шийдвэрийн хүрээнд гарч буй хууль тогтоомж, эрхзүйн актууд, стандарт, дүрэм, журмыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангуулах;

4.1.12. Үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, тулгамдсан асуудлыг зохицуулах, зөрчил дутагдлыг арилгах талаар нийтийн тээврийн байгууллагуудтай тогтмол санал солилцох, шаардлага тавих зорчигч урсгал болон бусад судалгааны ажлуудыг хамтран хийх;

4.1.13. Нийтийн тээврийн ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулах, дүгнэх, цуцлах, үйл ажиллагаанд нь түвшин тогтоох;

4.1.14. Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний бүртгэл мэдээлэл, хяналтын автомат системийн хэвийн үйл ажиллагааг хангах, өргөтгөх, мэдээллийн программ хангамжийг сайжруулах, хөлс төлөлтийн системд дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх;

4.1.15. Такси үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгоход мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх;

4.1.16. Такси үйлчилгээг орчин үеийн, тохилог, хүрээлэн буй орчинд ээлтэй, хотын өнгө үзэмжийг нэмсэн, түргэн шуурхай, аюулгүй байдлыг хангасан тээврийн зохих шаардлагыг бүрэн хангасан үйлчилгээнд хүргэх, таксины тоог хүртээмжтэй болгох, такси бүрийг нийслэл хотын газрын зураг, хайлтын системтэй болгох, тасалбарын төхөөрөмж, байршил тогтоогч суулгах зэрэг ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;

4.1.17. Нийтийн тээврийн үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаа, тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи мэдээллийг Захирагчийн ажлын албанд танилцуулах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

4.1.18. Нийслэлийн хэмжээнд нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний замын хуудас болон нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчийн тасалбар зэрэг тээвэрлэлтийн баримт бичгүүдэд хяналт тавьж, хэвлүүлэх;

4.1.19. Улсын болон нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.1.20. Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамааралтай бодлогын баримт бичиг, алба, хэлтсүүдийн чиг үүрэг, нийтийн тээврийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хийх, үнэлгээ өгөх;

4.1.21. Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах;

4.1.22. Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын дотоод журмын дагуу ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, өмч хөрөнгийн хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

4.1.23. Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн техникийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд хяналтын үзлэг, оношилгоо явуулах, дүгнэлт гаргах.

4.1.24. Нийслэл хотын дундуур дайран өнгөрч буй төмөр замын сүлжээг ашиглан төлөвлөлт хийж, нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх.

#### 4.2. Ачаа тээврийн талаарх хүлээх үүрэг

4.2.1. Автотээврийн олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомж, түүнд нийцүүлж Засгийн газар, Нийслэлийн Засаг дарга, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, стандартыг сахиулах;

4.2.2. Авто тээвэрлэлтийн үйл ажиллагаанд төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, тээврийн хэрэгсэл болон үйлчилгээнд тавигдах шаардлагыг стандартын дагуу хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд мэргэжлийн хяналтын байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах;

4.2.3. Улаанбаатар хот дотор болон хот орчимд энгийн ачаа болон аюултай ачаа, технологийн болон ахуйн тээвэр, тусгай зориулалтын тээвэр эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага, авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бий болгох;

4.2.4. Авто үйлчилгээнд зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээ авах, мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах;

4.2.5. Ачаа тээврийн хэрэгслийн ашиглалтын шаардлага, тээвэрлэлтийн нөхцөлийг хангуулах, хангасан байдалд хяналт тавих, тээвэрлэлтийн баримт бичгийн бүрдүүлэлтийг зохих шаардлагын дагуу гүйцэтгүүлэх;

4.2.6. Нийслэл хотод үйлчилгээ эрхэлдэг авто үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сан боловсруулах, авто үйлчилгээний байгууллагад холбогдох журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, хянах;

4.2.7. Авто үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, тэргүүний техник технологи, шинжлэх ухааны ололтыг сурталчлан нэвтрүүлэх, цаашдын үйл ажиллагааны чиг хандлагыг тодорхойлох, ажиллагсдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх анхаарах;

## Тав. Нийслэлийн Тээврийн газрын эрх

### 5.1. Нийтийн тээврийн талаар хэрэгжүүлэх эрх

5.1.1. Нийслэлийн нийтийн тээвэртэй холбоотой асуудлаар салбарын сайд болон Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжийн төслийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт танилцуулан холбогдох байгууллагуудаас санал авах, шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.1.2. Улаанбаатар хотын нийтийн тээврийн сүлжээг шинэчлэн зохион байгуулах, үйлчилгээний чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх;

5.1.3. Иргэдэд төрөөс үзүүлж байгаа нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг зохион байгуулалттайгаар тасалдуулах хууль бусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

5.1.4. Нийтийн тээврийн үйлчилгээний нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг ажилд томилох, чөлөөлөхөд санал өгөх, ажил үйлчилгээний талаар санал, дүгнэлт гаргах;

5.1.5. Нийтийн тээврийн үйлчилгээний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, соёлд тавих хяналт шалгалтын чиглэлээр төрийн бус байгууллага болон иргэний төлөөлөлтэй хамтарч ажиллах;

5.1.6. Ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээ, шаардлагатай тооцоо судалгааг нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагуудаас гаргуулан авах.

### 5.2. Ачаа тээврийн талаар хэрэгжүүлэх эрх

5.2.1. Нийслэлийн ачаа тээвэртэй холбоотой асуудлаар салбарын сайд болон Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжийн төслийг боловсруулах, холбогдох байгууллагуудаас санал авах, шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.2.2. Ачаа тээврийн үйлчилгээний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, соёл, аюулгүй байдалд тавих хяналт шалгалтын чиглэлээр төрийн бус байгууллага болон иргэний төлөөлөлтэй хамтарч ажиллах;

5.2.3 Ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээ, шаардлагатай тооцоо судалгааг ачаа тээврийн үйлчилгээний болон авто үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудаас гаргуулан авах.

## Зургаа. Хариуцлага

6.1. Газрын дарга, ажилтан албан хаагчид ажилдаа хариуцлагагүй хандсаны улмаас бусдын хууль ёсны эрх ашгийг хохироосон, бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн



тохиолдолд төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Долоо. Бусад зүйл

7.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

7.2. Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны  
*О.О. ДУМР* сарын *18*-ны өдрийн  
*А.Б.Н. ДУМР* захирамжийн хоёрдугаар  
хавсралт

УХ50011 9077243

НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН БҮТЭЦ,  
ОРОН ТООНЫ ХЯЗГААР

	Нэгж		Орон тоо
	1.	Захиргаа, удирдлагын хэлтэс	23
2.	Санхүүгийн хэлтэс	7	
3.	Тээврийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	9	
4.	Ачаа тээвэр, техник технологийн хэлтэс	11	
5.	Хяналт шалгалт, шуурхай зохицуулалтын хэлтэс	37	
6.	Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс	36	
7.	Хамтын ажиллагаа, маркетингийн тасаг	6	
	Албан хаагч	129	
	Гэрээт ажиллагсад	55 хүртэл	
Нийт	6 хэлтэс.	184	